СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

2025 IX

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

www.sukhbaatar.nso.mn

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025
9 сар

Баруун-Урт сум

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:
  АС Асгат
  БД Баяндэлгэр
  ДА Дарьганга
  МХ Мөнххаан
  НА Наран
  ОН Онгон
  СҮ Сүхбаатар
  ТШ Түвшинширээ
  ТЦ Түмэнцогт
  УБ Уулбаян
  ХА Халзан
  ЭЦ Эрдэнэцагаан
  БУ Баруун-Урт
- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-X ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

... Мэдээлэл байхгүй
0.0 Маш бага тоо
¹ Дахин
- Гүйцэтгэл байхгүй
* Урьдчилсан гүйцэтгэл

a^x х нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- мян. мянга
- % хувь
- кВт.ц киловатт цаг
- ккал килокалори
- $м^2$ метр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- ш ширхэг

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамааарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

	Ерөнхий тэмдэглэл	2
	Үндсэн үзүүлэлтүүд	4
I	Хүн ам	6
II	Хөдөлмөр	7
III	Нийгмийн даатгал, халамж	9
IV	Боловсрол	11
V	Эрүүл мэнд	12
VI	Соёл, урлаг	14
VII	Гэмт хэрэг	15
VIII	Мөнгө, банк	16
IX	Арилжааны даатгал	17
X	Орон нутгийн төсөв	18
XI	Төсөл, хөтөлбөр	19
XII	Үнэ	20
XIII	Хөдөө аж ахуй	24
XIV	Аж үйлдвэр	28
XV	Тээвэр	32
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	34
	Хавсралт хүснэгтүүд	36

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			Өөрчлөлт	
		2022	2023	2024	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Дүн	Хувь
ХӨДӨЛМӨР									
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	363	302	234	71	215	281	66	30.7
НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ									
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон дүн	сая.төг	11 093.1	13 019.8	16 461.7	9 573.6	12 307.4	14 291.2	1 983.8	16.1
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	хүн	27 369	29 221	29 423	25 040	26 325	21 805	-4 520	- 17.2
ЭРҮҮЛ МЭНД									
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 110	1 213	955	936	741	609	- 132	- 17.8
Амаржсан эх	хүн	1 112	1 209	949	932	735	609	- 126	- 17.1
Нас баралт	хүн	294	298	336	227	257	235	- 22	- 8.6
1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	9	6	7	4	6	6	-	-
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	4	5	3	5	3	1	- 2	- 66.7
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	5 369	924	617	784	507	631	124	24.5
СОЁЛ УРЛАГ									
Театрын тоглолт	тоо	31	41	57	41	24	60	36	150.0
Музейн үзэгчид	хүн	23 400	12 778	8 618	5 931	4 063	4 849	786	19.3
Номын сангийн уншигчид	хүн	20 146	37 708	14 769	27 969	7 895	6 754	-1 141	- 14.5
ГЭМТ ХЭРЭГ									
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	511	456	497	373	369	486	117	31.7
Хэрэгт холбогсод	хүн	409	328	343	216	231	293	62	26.8
МӨНГӨ, БАНК									
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	133.9	145.2	175.5	137.5	163.6	169.7	6.1	3.7
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	191.6	232.1	307.6	236.2	302.1	332.8	30.7	10.2
АРИЛЖААНЫ ДААТГАЛ									
Арилжааны даатгалын орлого	сая.төг	852.7	1 311.7	1 456.3	1 011.6	1 081.3	1 133.1	51.8	4.8
Арилжааны даатгалын нөхөн төлбөр	сая.төг	148.7	326.9	824.0	220.0	409.5	241.9	- 167.6	- 40.9
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ									
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	62.9	82.8	103.3	55.7	76.2	66.3	- 9.9	- 13.0
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	52.0	64.5	83.8	43.4	55.5	59.6	4.1	7.4
ҮНЭ									
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	12.7	7.1	7.6	9.1	3.6	3.8	0.2	-
АЖ ҮЙЛДВЭР									
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	149.8	221.3	299.9	155.6	200.3	336.7	136.4	68.1
Борлуулсан бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	322.8	432.1	447.7	341.4	284.9	415.0	130.1	45.7
ТЭЭВЭР									
Тээврийн орлого	тэрбум төгрөг	10.9	14.2	14.1	9.7	9.4	5.4	- 4.0	- 42.6
Тээсэн ачаа	мян.т	166.4	250.6	201.7	174.0	118.8	95.8	- 23.0	- 19.4
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	16.1	15.6	17.6	11.1	13.7	17.6	3.9	28.5

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			Өөрчлөлт	
		2022	2023	2024	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Дүн	Хувь
МАЛ АЖ АХУЙ									
Төллөсөн хээлтэгч	мян.тол	1 564.3	1 548.8	554.4	1 546.0	550.4	805.2	254.8	46.3
Гүү	мян.тол	93.2	90.2	46.1	89.5	44.3	78.8	34.5	77.9
Үнээ	мян.тол	98.8	94.4	42.6	92.7	40.6	57.3	16.7	41.1
Ингэ	мян.тол	1.5	1.3	0.9	1.3	0.8	1.0	0.2	21.8
Эм хонь	мян.тол	870.2	874.9	312.6	874.6	312.5	370.5	58.0	18.6
Эм ямаа	мян.тол	500.6	488.1	152.2	487.9	152.1	297.6	145.5	95.7
Бойжуулсан төл, бүгд	мян.тол	1 552.6	1 102.9	446.8	1 117.4	442.9	806.1	363.2	82.0
Унага	мян.тол	92.5	71.6	43.3	72.2	41.6	78.7	37.2	89.4
Тугал	мян.тол	98.1	78.3	40.1	77.2	38.1	57.2	19.1	50.2
Ботго	мян.тол	1.5	1.2	0.8	1.2	0.8	1.0	0.2	21.8
Хурга	мян.тол	865.2	624.1	246.9	631.7	246.8	370.9	124.1	50.3
Ишиг	мян.тол	495.2	327.7	115.7	335.1	115.6	298.3	182.7	2.6**
Том малын зүй бус хорогдол	мян.тол	15.8	578.4	1 824.9	566.5	1 820.1	3.1	-1 817.0	- 99.8
Адуу	мян.тол	1.7	27.2	72.9	26.8	72.4	0.6	- 71.8	- 99.2
Үхэр	мян.тол	1.7	30.4	135.8	29.7	135.5	0.3	- 135.2	- 99.8
Тэмээ	мян.тол	0.0	0.1	0.3	0.1	0.3	0.0	- 0.3	- 99.7
Хонь	мян.тол	6.1	272.5	1 067.1	266.2	1 063.6	1.1	-1 062.5	- 99.9
Ямаа	мян.тол	6.3	248.1	548.8	243.7	548.3	1.0	- 547.3	- 99.8
ГАЗАР ТАРИАЛАН									
Үр тариа	тн	3 478.0	2 865.0	2 395.0	1 795.0	353.4	1 065.0	711.6	3.0**
Тэжээлийн ургамал	тн	1 768.0	2 407.5	2 987.5	2 111.5	1 390.5	151.5	-1 239.0	- 89.1
Техникийн ургамал	тн	810.0	645.0	1 120.0	150.0	40.0	50.0	10.0	25.0
Төмс	тн	585.8	612.7	531.9	335.6	519.2	404.8	- 114.4	- 22.0
Хүнсний ногоо	тн	872.2	1 060.6	569.2	378.7	561.6	553.5	- 8.1	- 1.4

Тайлбар: ** дахин

ХҮН АМ

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 17.8 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээллээр 2025 оны эхний 9 дүгээр сард 609 эх амаржиж, 609 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 126 (17.1%)-аар, төрсөн хүүхэд 132 (17.8%)-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар



2025 оны эхний 9 дүгээр сард нас баралт 235 болж, өмнөх оны мөн үеэс 22 (8.6%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 9.2, нас баралт 3.5, ердийн цэвэр өсөлт 5.6 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 27.2 хувиар буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2025 оны 9 дүгээр сарын эцэст 281 болсны 138 (49.1%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 66 (30.7%) хүнээр, 2024 оны 12 дугаар сараас 47 (20.1%) хүнээр тус тус өссөн байна.

2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1219 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 591 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар**



Ажилгүй иргэдийн 187 (66.5%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1 (0.4%) нь магистр, доктор, 36 (12.8%) нь бакалавр, 9 (3.2%) нь тусгай мэргэжлийн дунд, 11 (3.9%) нь мэргэжлийн анхан шат, 110 (39.1%) нь бүрэн дунд, 67 (23.8%) нь суурь, 34 (12.1%) нь бага, 13 (4.6%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, 2025 оны 9 дүгээр сарын эцэст**

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.2 (16.8%) тэрбум төгрөгөөр өслөө.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 1.2 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар өссөн байна.
2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 10.9 мянган иргэнд 71.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос 8.0 мянган өндөр настанд 55.0 тэрбум төгрөг, 1.3 мянган тахир дутуу иргэнд 7.1 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 2.0 тэрбум төгрөг, 0.4 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 4.9 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 24 иргэнд 2.0 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна.
Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 918 (9.2%) хүнээр, нийт тэтгэвэр олголт 10.2 (16.8%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2025 оны эхний 9 дүгээр сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1.5 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 27 (1.8%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 4.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.6 (13.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2025 оны эхний 9 дүгээр сард 3.1 мянган хүн хамрагдсаны 50.0 хувь нь асаргааны тэтгэмжид, 50.0 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

2025 оны эхний 9 дүгээр сард нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 14.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1.9 (16.1%) тэрбум төгрөгөөр өсөж, 21.8 мянган хүн нийгмийн халамжын үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.5 (17.2%) мянган хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-IX		2024 I-IX		2025 I-IX		Өөрчлөлт	
							Дүн	Хувь
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг		
Бүгд	**25 040**	**9 573.6**	**26 325**	**12 307.4**	**21 805**	**14 291.2**	**1 983.8**	**16.1**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	5 000	6 036.3	5 025	8 848.9	5 291	10 105.6	1 256.7	14.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 457	3 660.0	1 516	4 595.4	1 543	5 215.5	620.1	13.5
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 422	2 224.1	2 807	4 148.8	3 071	4 818.3	669.5	16.1
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	962	82.4	685	70.7	677	71.8	1.1	1.6
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 795	747.7	5 967	759.9	6 237	1 564.8	804.9	2.0[1]
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	5 225	407.6	6 142	325.3	1 695	356.9	31.6	9.7
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	7	0.8	10	1.9	11	3.1	1.2	63.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	389	104.3	561	146.4	427	106.3	-40.1	-27.4
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	5 375	1 777.0	4 929	1 688.0	4 254	1 581.7	-106.3	-6.3
Насны хишиг	3 249	500.0	3 691	537.0	3 890	572.8	35.8	6.7

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 677 хүн хамрагдсан нь өмнөх оноос 8 (1.2%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын газрын нийгмийн даатгалын орлого, зарлагын улирлын мэдээ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамжийн сарын мэдээ

БОЛОВСРОЛ

2025-2026 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо өмнөх оноос 322-оор өслөө.

Ерөнхий боловсролын сургуульд 2025-2026 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 14.8 мянган суралцагчид байгаагийн 7.4 (50.0%) мянга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 322 (2.2%) хүүхдээр өсчээ.
Нийт суралцагчдын 7.1 (47.7%) мянга нь 1-5-р ангид, 5.4 (36.2%) мянга нь 6-9-р ангид, 2.4 (16.1%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.5 мянган суралцагчид элсэн орсны 721 (49.3%) эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 40 (2.8%) суралцагчаар өссөн байна. Мөн 12-р ангид 716 суралцагчид байгаагийн 407 (56.9%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 55 (8.3%) суралцагчаар өссөн байна.

Энэ хичээлийн жилд 489 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 30.2 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 22 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Нийт ажиллагсдын 690 (56.7%) үндсэн багш байна. Үүний 572 (82.9%) нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 22 (3.3%) багшаар өссөн байна.

Дотуур байранд 1041 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 7 (0.7%) сурагчаар буурчээ.

ЗУРАГ 5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТОО



Сургуулийн өмнөх боловсрол 2025-2026 оны хичээлийн жилд 166 бүлэгт 5.2 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 2.5 (48.6%) мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 252 (4.6%) хүүхдээр буурчээ.

2025-2026 оны хичээлийн жилд СӨБ-д 691 ажиллагсад байгаагийн 193 (27.9%) нь үндсэн багш, 152 (22.0%) нь туслах багш байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үндсэн багшийн тоо 1 (0.5%)-р, туслах багшийг тоо 1 (0.7%)-ээр тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2025-2026 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 15 мэргэжлээр 473 суралцагчид суралцаж байгаагийн 167 (35.8%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 68 (2.2%) суралцагчаар өссөн байна.

Нийт суралцагчдын 144 (30.4%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 77 (16.2%) барилга бүтэц, угсралт, 35 (7.4%) цахилгаан хангамж. тоног төхөөрөмж ашиглалт, 41 (8.7%) механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар, үйлчилгээ, 57 (12.0%) хоолны үйлчилгээ, 28 (5.9%) үс засал, гоо сайхны үйлчилгээ, 33 (7.0%) оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 41 (8.7%) гагнуурчин, 30 (6.3%) электрон тоног төхөөрөмж ашиглалт, засвар үйлчилгээ гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Эх үүсвэр: Боловсролын газрын мэдээ.

ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2025 оны эхний 9 дүгээр сард 609 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 126 (17.1%) эхээр буурсан байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 529 (86.9%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 25 (4.1%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Амаржсан эх	932	735	609	-126	-17.1
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	903	692	558	-134	-19.4
Гэрийн төрөлт	4	2	2	0	0.0
Амьд төрсөн хүүхэд	936	741	609	-132	-17.8
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	890	673	529	-144	-21.4
Төрөлхийн гажигтай төрсөн	6	8	2	-6	-75.0
2500 граммаас доош жинтэй төрсөн	31	26	25	-1	-3.8
Амьгүй төрсөн хүүхэд	4	-	3	3	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	4. 3	-	4. 9	4. 9	-

2025 оны эхний 9 дүгээр сард нас баралтын 235 тохиолдол бүртгэгдсэний 21 (8.9%) нь осол гэмтлийн улмаас, 88 (37.4%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Нас баралт	227	257	235	-22	-8.6
Эмнэлгийн нас баралт	40	54	39	-15	-27.8
Эхийн эндэгдэл	-	1	-	-1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	46	38	21	-17	-44.7
Хорт хавдрын өвчлөл нас баралт	57	74	88	14	18.9
0-1 насны эндэгдэл	4	6	6	-	-
1-5 хүртэлх насны эндэгдэл	5	3	1	-2	-66.7

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 оны эхний 9 дүгээр сард 631 болж, өмнөх оны мөн үеэс 124 (24.5%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Халдварт өвчин	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Өөрчлөлт	
	Хүн			Дүн	Хувь
Бүгд	**784**	**507**	**631**	**124**	**24.5**
Вируст гепатит	3	1	-	-1	-
Цусан суулга	25	13	14	1	7.7
Гахайн хавдар	2	1	-	-1	-
Бруцеллёз	-	1	-	-1	-
Салхинцэцэг	202	132	219	87	65.9
Энтервируст халдвар	104	83	3	-80	-96.4
Улаан эсэргэнэ	13	-	2	2	-
Ecoli-оор/ A04.4/	-	14	-	-14	-
Ёлом	1	-	3	3	-
Салмонеллт	19	23	11	-12	-52.2
Гар хөл амны өвчин	119	84	48	-36	-42.9
Нярайн бактерт үржил	-	1	-	-1	-
Хачигт	4	1	-	-1	-
Халдварт эритема /B08.3/	-	-	35	35	-
Сүрьеэ	46	44	37	-7	-15.9
Тэмбүү	24	29	50	21	72.4
Заг	38	52	59	7	13.5
Трихомониаз	43	28	18	-10	-35.7
Ковид-19	141	-	-	-	-
Улаанбурхан	-	-	131	131	-
Менингококкт	-	-	1	1	-

Халдварт өвчний тохиолдлуудаас салхинцэцгээр 87 (65.9%)-аар, заг хүйтнээр өвчлөгчид 7 (13.5%)-аар, тэмбүү 21 (72.4%)-оор нэмэгдсэн нь өндөр өсөлтэй байна.

Шинээр халдварт улаан бурхан өвчний 131, менингококкт 1 тохиолдол бүртгэгджээ.

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 206.6 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.3 (1.6%) мянган хүнээр өсөж, 11.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 52.2 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 10.6 (25.6%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 11.6 мянган удаа гарсны 1.6 (13.8%) мянга нь алсын дуудлага байгаа нь өмнөх оны мөн үеэс 834 (34.2%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

СОЁЛ, УРЛАГ

Хөгжимт жүжгийн театр 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 13.7 мянган үзэгчдэд 60 удаа тоглолтоор үйлчилсэн байна.

Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 36 (2.5 дахин)-аар өсөж, танхимын үзэгчдийн тоо 0.7 (5.5%) мянгаар буурсан байна.

ЗУРАГ 7. НИЙТ ТОГЛОЛТЫН ТОО



ЗУРАГ 8. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Угсаатны зүйн музей 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 4.8 мянган хүнд 2.7 мянган үзмэрээр үйлчилж, 2.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзмэрийн тоо 197 (7.8%)-аар, нийт үзвэр үзэгчдийн тоо 786 (19.3%)-аар, орлого өмнөх оны мөн үеэс 0.2 (7.7%) сая төгрөгөөр өсжээ.

ЗУРАГ 9. НИЙТ ҮЗМЭРИЙН ТОО



ЗУРАГ 10. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Номын сан 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 50.8 мянган номноос 8.7 мянган номоор 6.8 мянган уншигчдад үйлчилжээ.

Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.4 (0.8%) мянгаар, уншигчдын тоо 0.2 (3.9%) мянган хүнээр өсжээ.

ЗУРАГ 11. НИЙТ НОМЫН ТОО, мян ширхэг



ЗУРАГ 12. НИЙТ УНШИГЧДЫН ТОО, мян.хүн



Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Жаахан шарга хөгжимт жүжгийн театр, Усгаатны зүйн музей, Нийтийн номын сангийн улирлын мэдээ.

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 117 (31.7%)-аар өссөн байна.

2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 486 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 16 хүн нас барж, 101 хүн гэмтэж бэртсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 1883.3 сая төгрөгийн хохирол учирсны 42.4 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 293 хүн холбогдон сэжиглэгдсэний 175 (40.3%) хүн нь согтуугаар, 14 (4.8%) хүн нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар нийт 38 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 198 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 486 гэмт хэргээс, илрүүлэлт 51.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 нэгжээр өссөн байна.

ЗУРАГ 13. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ ЗЭЭЛ

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 2025 оны оны 9 дүгээр сарын эцэст 3.3 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.

2025 оны 9 дүгээр сарын эцэст Сүхбаатар аймаг дахь Монгол банкны салбарын мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 332.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 5.1 (1.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 30.7 (10.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 169.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 1.3 (0.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 6.1 (3.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт хадгаламжийн 84.4 хувь нь хугацаатай, 15.6 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ЗУРАГ 14. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

АРИЛЖААНЫ ДААТГАЛ

Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өсжээ.

Даатгалын хураамжийн орлого 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 1.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 51.8 (4.8%) сая төгрөгөөр өсөж, даатгалын нөхөн төлбөрт 241.9 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 167.6 (40.9%) сая төгрөгөөр буурсан байна.

Даатгалын хураамжийн 67.1 хувийг сайн дурын даатгал, 32.9 хувийг албан журмын даатгал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Өөрчлөлт	
	сая төгрөг			Дүн	хувь
Хураамжийн орлого	1 011.6	1 081.3	1 133.1	51.8	4.8
Нөхөн төлбөр	220.0	409.5	241.9	-167.6	-40.9
Даатгуулагчдын тоо	28 081	22 729	33 039	10 310	45.4

Даатгалын хураамжийн нийт орлогын 372.5 (32.9%)-ийг сая төгрөгийг жолоочийн хариуцлагын даатгал, 291.8 (25.8%)-ийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 96.2 (8.5%)-ийг гэнэтийн ослын даатгал, 130.9 (11.6%) зуучлалын орлого эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөрийн 43.2 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 44.7 хувийг тээврийн хэрэгслийн даатгал, 1.3 хувийг гэнэтийн ослын даатгал, 1.4 хувийг хөдөлмөрийн чадвараа түр алдсаны даатгал, 8.1 хувийг хурдан морь унаач хүүхдийн даатгал тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Даатгалын нөхөн төлбөр: Гэрээний дагуу даатгалын тохиолдолд үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажилаагаа юм.

Даатгалын хураамж: Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.
Эх үүсвэр: Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны даатгалуудын улирлын мэдээлэл

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар буурчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 9 дүгээр сард 66.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9.9 (13.0%) тэрбум төгрөгөөр буурч, төсвийн зарлага санхүүжилт 59.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.4 (7.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 15. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Аймгийн нийт төсвийн 48.6 хувийг орон нутгийн төсвийн орлого, 16.9 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 11.0 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 18.0 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 0.1 хувийг урьд оны үлдэгдэл, 5.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Аймгийн хэмжээнд малжуулах хөтөлбөрт 90 өрхийг 4.5 мянган толгой мал 720.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлжээ.

Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 23 иргэнд 225.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 иргэнд 200.0 сая төгрөг, мод тарих арга хэмжээнд 350 иргэнд 202.9 сая төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 12 иргэнд 13.1 сая төгрөг, залуучуудын гарааны бизнесийн санхүүгийн дэмжлэг 2 иргэнд 30.0 сая төгрөг, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 90 өрхөд 720.0 сая төгрөгөөр 4,5 мянган толгой малыг тус тус олгоод байна.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраас мэдээллийг авч нэгтгэн оруулдаг.

ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 9 дүгээр сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.6 хувь, өмнөх оны эцсээс 3.8 хувь, өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. **ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар**



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 23.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь, тээврийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.6 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 9 дүгээр сард өмнөх оны эцсээс 3.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.7 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.9

хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2025 оны 9 дүгээр сард

Бараа үйлчилгээний бүлэг	2025 IX / 2024 IX	2025 IX / 2024 XII	2025 IX / 2025 VIII
	хувь		
Ерөнхий индекс	**8.6**	**3.8**	**0.2**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	7.0	5.4	0.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	3.1	2.2	0.0
Хувцас, бөс бараа, гутал	23.6	4.3	0.9
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.8	1.1	0.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	3.2	1.4	0.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	2.3	1.8	0.2
Тээвэр	2.1	2.1	-0.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.4	1.3	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	1.0	-0.5	1.0
Боловсролын үйлчилгээ	0.0	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	17.6	10.7	0.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	65.0	65.0	0.0
Бусад бараа, үйлчилгээ	9.8	8.9	0.1

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2025 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өсөхөд гахайн махны үнэ дунджаар 0.9 хувь, үхрийн мах 14.9 хувь, хонь, ямааны мах 21.0 хувь, адууны мах 16.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хязаалан гунан үхрийн үнэ Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2025 оны 9 дүгээр сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.2 сая төгрөг болж, 191.7 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.2 сая төгрөг болж, 185.0 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 2.3 сая төгрөг болж, 724.2 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 307.7 мянган төгрөг болж, 70.8 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 202.5 мянган төгрөг болж, 50.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард

Төрөл	2022 IX	2023 IX	2024 IX	2025 IX	Өөрчлөлт	
	мян.төг				Дүн	Хувь
Нас гүйцсэн ат	1 250.0	1 212.5	983.3	1 175.0	191.7	19.5
Соёолон үрээ	958.3	1 084.5	987.5	1 172.5	185.0	18.7
Хязаалан гуна	1 410.0	1 605.6	1 580.0	2 304.2	724.2	45.8
Эр хонь	204.2	218.3	236.9	307.7	70.8	29.9
Эр ямаа	133.1	141.8	152.5	202.5	50.0	32.8

Хязаалан гунан үхрийн үнэ 2025 оны 9 дүгээр сард Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг, Түвшинширээ суманд хамгийн бага буюу 1.5 сая төгрөг байна.

ЗУРАГ 18. НАС ГҮЙЦСЭН ЭР ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2025 оны 9 дүгээр сард, мянган төгрөгөөр



Аргалын үнэ 2025 оны 9 дүгээр сард 130.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.0 (54.8%) мянган төгрөг, хөрзөнгийн дундаж үнэ 234.3 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 85.0 (56.9%) мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 19. **МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард, төгрөгөөр**



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдаануы цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

МАЛ АЖ АХУЙ

Мал төллөлт 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд 78.1 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар оны эхний төллөх насны 1.0 сая хээлтэгч малын 805.2 (78.1%) мянга нь төлөжээ. Гүүний 69.1 хувь, үнээний 69.6 хувь, ингэний 39.6 хувь, эм хонины 80.0 хувь, эм ямааны 80.7 хувь нь төллөсөн байна.

ХҮСНЭГТ 8. **МАЛ ТӨЛЛӨЛТ, төрлөөр**

Малын төрөл	Оны эхний хээлтэгч			Төллөсөн хээлтэгч			Төллөлтийн хувь		
	2023	2024	2025	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX
	мянган толгой						хувь		
Дүн	**2 063.7**	**1 859.6**	**1 030.8**	**1 546.0**	**550.4**	**805.2**	**74.9**	**29.6**	**78.1**
Адуу	128.1	127.5	114.1	89.5	44.3	78.8	69.9	34.8	69.1
Үхэр	134.9	127.2	82.3	92.7	40.6	57.3	68.7	31.9	69.6
Тэмээ	3.1	3.0	2.5	1.3	0.8	1.0	41.6	28.2	39.6
Хонь	1 130.5	1 027.5	463.3	874.6	312.5	370.5	77.4	30.4	80.0
Ямаа	667.2	574.3	368.6	488.0	152.1	297.6	73.1	26.5	80.7

ЗУРАГ 20. **ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛЛӨЛТ, мянган толгой**



Бойжуулсан төл 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 806.1 мянга болж, бойжилтын хувь 99.8 хувь байна. Гарсан унаганы 99.9 хувь, тугалын 99.9 хувь, ботгоны 99.9 хувь, хурганы 99.8 хувь, ишигний 99.8 хувь нь бойжжээ.

Аймгийн хэмжээнд 1.5 мянган толгой төл мал хорогдсоныг төрлөөр нь авч үзвэл: унага 86, тугал 56, ботго 1, хурга 676, ишиг 662 толгой төл мал тус тус хорогдоод байна.

ХҮСНЭГТ 9. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар, мянган толгой

Төлийн төрөл	Гарсан төл			Бойжуулсан төл			Төл бойжилтын хувь		
	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX
Дүн	**1549.2**	**550.8**	**807.6**	**1 117.4**	**442.9**	**806.1**	**72.1**	**80.4**	**99.8**
Унага	89.5	44.3	78.8	72.2	41.6	78.7	80.7	93.8	99.9
Тугал	92.7	40.6	57.3	77.2	38.1	57.2	83.3	93.8	99.9
Ботго	1.3	0.8	1.0	1.2	0.8	1.0	95.2	93.9	99.9
Хурга	876.3	312.8	371.6	631.7	246.8	370.9	72.1	78.9	99.8
Ямаа	489.4	152.3	299.0	335.1	115.6	298.3	68.5	75.9	99.8

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар оны эхний малын 0.2 хувь буюу 3.1 мянган толгой мал хорогдоод байна. Нийт хорогдлыг төрлөөр нь авч үзвэл адуу 649 толгой, үхэр 313 толгой, тэмээ 1 толгой, хонь 1.1 мянган толгой, ямаа 1.0 мянган толгой мал тус тус хорогдсон байна.

ХҮСНЭГТ 10. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX
	мянган толгой			хувь		
Дүн	**566.5**	**1 820.1**	**3.1**	**12.2**	**47.2**	**0.2**
Адуу	26.8	72.4	0.6	6.7	19.8	0.2
Үхэр	29.7	135.4	0.3	8.7	44.6	0.2
Тэмээ	0.1	0.3	0.0	1.2	4.1	0.0
Хонь	266.2	1 063.6	1.1	11.0	52.7	0.1
Ямаа	243.7	548.3	1.0	16.4	47.2	0.2

Нийт хорогдсон малын 36.7 хувийг хонь, 32.5 хувийг ямаа эзэлж байна. Хорогдлыг сумдаар нь авч үзэхэд 2025 оны эхний 9 дүгээр сард Баруун-Урт суманд 528 (16.9 хувь), Мөнххаан суманд 800 (25.6 хувь), Дарьганга суманд 490 (15.7 хувь), Сүхбаатар суманд 285 (9.1 хувь), Асгат суманд 300 (9.6 хувь), Түмэнцогт суманд 250 (8.0 хувь) толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 84.8 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 21. **ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумдаар**



ЗУРАГ 22. **ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, төрлөөр**



2025 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 21 толгой хээлтүүлэгч, 797 толгой хээлтэгч, 2.3 мянган толгой таваарын мал хорогдоод байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

ГАЗАР ТАРИАЛАН

Хураасан хүнсний ногоо өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурлаа.

Сүхбаатар аймгийн хэмжээнд ургац хураалтын явцын мэдээгээр 2025 оны 9 дүгээр сарын байдлаар төмс 404.8 тонн, хүнсний ногоо 553.5 тонн, үр тариа 1.1 мянган тонн, тэжээлийн ургамал 151.5 тонн, техникийн ургамал 50.0 тонн бэлтгэсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураасан үр тариа 711.6 (3.0 дахин) тонн, техникийн ургамал 10 (25.0%) тонноор өсөж, төмс 114.4 (22.0%) тонн, хүнсний ногоо 8.1 (1.4%) тонн, тэжээлийн ургамал 1.2 (89.1%)мянган тонн тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 11. ХУРААСАН УРГАЦ, тн

Төрөл	Жил			Сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2023 I-IX	2024 I-IX	2025 I-IX	Дүн	Хувь
	тонн							
Үр тариа	3 478.0	2 865.0	2 395.0	1 795.0	353.4	1 065.0	50.0	3.0 дахин
Төмс	585.8	612.7	531.9	335.6	519.2	404.8	- 114.4	- 22.0
Хүнсний ногоо	872.2	1 060.6	569.2	378.8	561.6	553.5	- 8.1	- 1.4
Тэжээлийн ургамал	1 768.0	2 407.5	2 987.5	2 111.5	1 390.5	151.5	-1 239.0	-89.1
Техникийн ургамал	810.0	645.0	1 120.0	150.0	40.0	50.0	10.0	25.0
Бэлтгэсэн өвс	18 132.8	33 736.1	37 321.3	1 068.0	2 373.6	10 476.8	8 103.2	4.4 дахин

ЗУРАГ 23. **ХУРААСАН ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар**



Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 68.2 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 336.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 136.5 (68.2%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 136.9 (78.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 11. **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар**

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-IX	2025* I-IX	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	**221 266.6**	**301 412.6**	**200 250.2**	**336 745.1**	**136 494.9**	**68.2**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	181 814.1	262 956.9	174 443.9	311 334.5	136 890.6	78.5
Боловсруулах аж үйлдвэр	29 791.3	26 755.2	18 348.2	16 738.0	-1 610.2	- 8.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 005.5	2 821.4	1 684.7	1 588.5	- 96.2	- 5.7
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 655.6	8 879.1	5 773.4	7 084.1	1 310.7	22.7

